



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

ХУГАЦААТАЙ БАЙГУУЛСАН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ АНХ БАЙГУУЛСАН ХУГАЦАА БОЛОН СУНГАСАН ХУГАЦААНЫ НИЙЛБЭР ХОЁР ЖИЛЭЭС ДЭЭШ БОЛ ХУГАЦААГҮЙ ГЭРЭЭНД ТООЦНО

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/00195

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 11 сарын 13-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Т.Ө нь “Н” ХХК-д холбогдуулан нэхэмжлэл гаргахдаа “...2021 оны 11 сараас эхлэн дампын оператороор ажиллаж байсан ба эрхэлсэн ажилдаа алдаа зөрчил гаргаагүй, ... хөдөлмөрийн гэрээний хугацааг үйл явдлаар тодорхойлох ёстой бөгөөд гэрээ сунгасан хугацааны нийлбэр 2 жилээс дээш байвал хугацаагүй байгуулсанд тооцох зохицуулалттай тул хууль зөрчиж ажлаас халсан, “Н” ХХК-ийн “Э” ХК-тай байгуулсан төслийн ажил дууссан гэж тайлбарласан ч хариуцагч одоо хүртэл тухайн газраа ажлаа үргэлжлүүлж байна...” гэсэн.

Хариуцагч нэхэмжлэлийг эс зөвшөөрч “...Т.Ө-тэй анх туршилтын хугацаагаар гэрээ байгуулсан, дараа нь “Э” ХК-тай 2021.11.09-ний өдөр байгуулсан гэрээний дагуу 36 сарын хугацаатай төслийн ажил гүйцэтгэхдээ ажилтнуудтай Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.6-д зааснаар хугацаатай гэрээ байгуулсан,... “Э” ХК-тай байгуулсан төслийн ажлын гэрээний хугацаа дуусгавар болж буйтай холбогдуулан 2024.11.22-ны өдөр Т.Ө-н хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болж байгаа талаар мэдэгдэж, 2025.01.06-ны өдөр ажлаас чөлөөлсөн...” гэж маргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүх:** “...Хариуцагч “Н” ХХК нь “Э” ХК-тай байгуулсан 2021.11.09-ний өдрийн ЭТТ2021-705 тоот гэрээний хүрээнд нэхэмжлэгч Т.Ө-тэй

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/10932?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1



- Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5²-д зааснаар хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан, нэхэмжлэгчийн төсөл дуусаагүй байхад ажил олгогч нэг талын санаачилгаар дуусгасан гэх тайлбар үндэслэлгүй, ЭТТ2021-705 тоот гэрээний хугацаа дууссан тул Т.Ө-н хөдөлмөрийн гэрээг цуцалсан нь үндэслэлтэй...” хэмээн үзэж нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. (9)³
2. **Давж заалдах шатны шүүх:** “...Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4⁴-т зааснаар нэхэмжлэгчтэй **анх байгуулсан хөдөлмөрийн гэрээний хугацаа, сунгасан хугацааны нийлбэр 2 жилээс давсан тул Т.Ө-н хөдөлмөрийн гэрээг хугацаагүй гэрээнд тооцох бөгөөд ажил олгогчийн шийдвэр үндэслэлгүй...**” гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ. (10)
 3. **Хяналтын шатны шүүх:** “...хөдөлмөрийн гэрээг хугацаатай болон хугацаагүй байгуулж болох ба хугацаатай байгуулах тохиолдлыг хуульд тусгайлан заасан. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д хөдөлмөрийн гэрээг хугацаатай байгуулах нөхцөлүүдийг нэрлэн заасан ба мөн хуулийн 50.1.6-д заасан “*санхүүжилт, хийгдэх ажлын цар хүрээтэй холбоотой цаг хугацаагаар хязгаарлагдсан ажил үүрэг гүйцэтгүүлэх*” тохиолдол үүнд хамаарч байна.”, “...хугацаатай хөдөлмөрийн гэрээг тодорхой үндэслэл, шалтгаантай тохиолдлуудад л байгуулахыг 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулиар зөвшөөрсөн бөгөөд бусад тохиолдолд байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулахаар зохицуулсан.” (16)
 4. **Мөн хугацаатай байгуулсан гэрээний хугацааг** “... анх байгуулсан болон сунгасан хугацааны нийлбэр хоёр жилээс...” дээшгүй байхаар хязгаарлаж өгснөөр ажилтны тогтвортой ажиллах эрх ашгийг хамгаалах хуулийн зорилготой холбоотой байна. (17)
 5. Нөгөө талаар, хугацаатай хөдөлмөрийн гэрээний талуудын тохиролцсон хугацаа дуусахаас гадна ажил олгогчийн бусадтай байгуулсан аливаа гэрээний зорилго биелэгдсэн тохиолдолд ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болохыг Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.6-д заасан зохицуулалт мөн агуулсан байна. (19)
 6. Иймд ажилтантай хөдөлмөрийн гэрээг хугацаатай байгуулах **Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.6-д заасан хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон ажил олгогчийн шийдвэр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийг зөрчсөн** гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн магадлал үндэслэлтэй гэж дүгнэсэн.

---o0o---

² Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5-д “Хөдөлмөрийн гэрээний хугацааг хуанлийн жил, сар, өдрөөр, эсхүл энэ хуулийн 50.1.3, 50.1.4, 50.1.5, 50.1.6-д заасан ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хугацаа, зайлшгүй бий болох үйл явдлаар тодорхойлно.”

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁴ Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4-т “Энэ хуулийн 58.1.3, 139.1-д зааснаас бусад тохиолдолд хугацаатай байгуулсан гэрээний анх байгуулсан болон сунгасан хугацааны нийлбэр хоёр жилээс дээш бол уг гэрээг хугацаагүй байгуулагдсанд тооцно.”